

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-13

- 
1. Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсох 4-12
2. “Монгол Улс нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 12-13

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 03 дугаар сарын 28-ны өдөр  
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адъяаа, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар;

Чөлөөтэй: Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар.

**Нэг.Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, мөн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч Л.Мандваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Олон улсын гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө.Ундрах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрхийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн Гадаадад ажиллах хүч илгээх, бодлого, зохицуулалт, судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах шинжээч Г.Энхмаа, Хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нямсүвд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлангийн талаар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг сонсов.

*Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Монгол Улс нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, мөн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч Л.Мандваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын Олон улсын гэрээ, эрх зүй, хамтын ажиллагааны хэлтсийн дарга Ө.Ундрах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрхийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, мөн яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн Гадаадад ажиллах хүч илгээх, бодлого, зохицуулалт, судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах шинжээч Г.Энхмаа, Хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээр хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Нямсүвд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Дөлгөөн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Монгол Улс нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Монгол Улс нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 33 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 15 цаг 14 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим,  
14 цаг 41 минут

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрбэ. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Ганибалын Амартүвшин, Энхтайваны Бат-Амгалан, Дашидондогийн Ганбат, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Цэндийн Сандаг-Очир, Цэдэвийн Сэргэлэн, Ням-Осорын Учрал, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гэсэн гишүүд хуралд ирсэн байна.

Ингээд ирц танилцуулж дууслаа. Ирц бүрдсэн тул хурал хүчин төгөлдөр нээгдээд явж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал дүгнэлттэй танилцах,

2. “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Саналаа хэлнэ үү. Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. 1 дүгээр асуудал.

**Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлттэй танилцъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хэн, хэн ирсэн байна?

Хуралдаанд оролцож байгаа мэргэжилтнүүдийг танилцуулъя.

Ч.Нарантуяа ХЗДХЯ-ны Гэрээ, эрх зүйн хамтын ажиллагааны газрын дарга, Л.Мандваа ХЗДХЯ-ны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч, Д.Ариунтуяа БОАЖЯ-ны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын ахлах шинжээч, Ө.Ундрах ХЭҮК-ын олон улсын гэрээ эрх зүйн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Г.Энхмаа Гадаад ажиллах хүч илгээх, бодлого, зохицуулалт, судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах шинжээч, Б.Нямсүвд НҮБ-ын хамтын ажиллагаа, гэрээ хэлэлцээр, конвенц хариуцсан ахлах мэргэжилтэн. Энэ аль байгууллагынх билээ? Нямсүвд. НҮБ-ын хамтын ажиллагаа. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны хүн байгаа юм байна. Ойлголоо.

Ингээд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч Цэндийн Мөнх-Оргил гишүүн танилцуулна.

Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 09 дүгээр тогтоолоор Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан, Бямбацогт, Пүрэвдорж, Сэргэлэн нарын бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан холбогдох байгууллагуудтай хамтран биелүүлнэ гэж заасан тул ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Улсын Их

Хурлын Тамгын газар, ГХЯ, ХЗДХЯ, БОАЖЯ, БШУЯ, ХНХЯ, ЭМЯ, БХЯ, ХЭҮК, ШЕЗ, Монгол УЕПГ, ЦЕГ-ын төлөөллийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа авлаа.

Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 193 дугаар тогтоолыг баталж, Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам, тайлан хариуцан боловсруулах байгууллагын хуваарийг баталсан бөгөөд нийт 30 гэрээний хэрэгжилтийг гарган тайлагнаж байхаар тусгасан.

Ажлын хэсэг 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт түүний 2 дугаар протокол, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, түүний нэмэлт протокол, хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц, Арьс үндсээр алагчлан үзэх үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц эдгээртэй холбоотой гэрээний хороодоос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг танилцуулж, холбогдох үүрэг чиглэлийг авсан болно.

Мөн ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдөр Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын факт, түүний нэмэлт протокол, эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протокол, хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 138 дугаар конвенц, түүний 146 дугаар зөвлөмж, Албадан хөдөлмөрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц, Алагчлахгүй байх тухай олон



улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, түүний 111 дүгээр зөвлөмж, Хүүхдийн эрхийн тухай конвенц, хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протокол, Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, Ажил эрхлэлтийн үйлчилгээний тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88 дугаар конвенц, Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт мэдээлэл хүргүүлэх журмын тухай 3 дугаар протокол, Уурхай дахь Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 176 дугаар конвенц, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц, Тамхины хяналтын тухай суурь конвенц, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протокол, Мансууруулах эмийн тухай конвенц, Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенцын хэрэгжилтийг танилцуулж, холбогдох үүрэг чиглэлийг авсан болно.

Ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанаар Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенц, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмийн конвенц, Амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээр, Мөнгөн усны тухай Минаматагийн конвенцын хэрэгжилтийг танилцуулж, холбогдох үүрэг чиглэлийг өгсөн болно.

Ажлын хэсэг Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын 30 гэрээний хүрээнд Монгол Улсын хүлээсэн үүрэг, НҮБ-ын гэрээний хороодоос өгсөн

зөвлөмжийн хэрэгжилтийг гаргасан бөгөөд үүрэг зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дараах хүндрэл бэрхиээл байна гэж үзлээ. Үүнд:

1. Үндэсний хууль тогтоомжийг олон талт олон улсын гэрээнд нийцүүлэх хүрээнд

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль санаачлах эрхтэй субъектуудийн зүгээс санаачлан боловсруулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцэх үед холбогдох олон улсын гэрээний зохицуулалтыг хэрхэн тусгасан талаар хянан үздэг эрх зүйн орчин дутагдалтай байна гэж зөвлөмж гаргасан.

Төсөл санаачлагч хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үзэл баримтлалд энэ талаар дурддаг хэдий ч хэрхэн судлан үзсэн талаар мэдээлэл хангалтгүй байна. Иймд Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн явцад үүнийг анхаарч үзэх шаардлагатай байна гэж үзэж байгаа юм.

Түүнчлэн олон талт олон улсын гэрээнд нэгдэн орохдоо үүсэж болох хууль, эрх зүй, нийгэм, эдийн засгийн, санхүүгийн үр нөлөө, манай улсын хүлээх үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх боломжтой эсэхийг урьдчилан нарийвчилж судлахгүйгээр шийдвэрлэж байгаа нь таамаглаагүй үр дагавар бий болох, дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөх, улмаар гэрээг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхиээл үүсэхэд хүргэж байна.

2. Төрийн захиргааны төв байгууллага уялдаа холбоо, хүний нөөцийн асуудал.

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон

улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох байгууллагатай хамтран биелүүлнэ гэж заасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг боловсруулах, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын зохион байгуулах төрийн захиргааны төв байгууллагын хуваарийг баталсан.

Тус хуваарийн дагуу конвенцын хэрэгжилтийн тайланг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан нэгтгэж, ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газар хянуулан холбогдох гэрээний хороонд хүргүүлж ирсэн. Зарим олон улсын гэрээний тухай зохицуулалт нь салбар дундын хамтын ажиллагааны үр дүнг шаарддаг бөгөөд зөвхөн нэг яам хариуцан шийдвэрлэх асуудал биш байдаг. Түүнчлэн олон улсын гэрээний хэрэгжилтийн тайлан боловсруулах явцад төрийн захиргааны төв байгууллага хоорондын уялдаа холбоо хангалтгүй байгаагаас шалтгаалан мэдээлэл орхигддог, тайланг дутуу бичдэг, гэрээний хэрэгжилтийн талаар тайлан хамгаалах үед гэрээний хороодод өгч байгаа мэдээлэл зөрөөтэй байх тохиолдол гардаг төдийгүй үүнээс улбаалан гэрээний хороодоос сөрөг зөвлөмж авдаг асуудал гарсаар байна. Энэ нь тайлан боловсруулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, дамжуулах нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүйтэй холбоотой юм.

Түүнчлэн гэрээний хэрэгжилтийн тайлан, мэдээлэл боловсруулах чадвартай хүний нөөцийн асуудал бүх салбар яаманд дутмаг байна. Тухайн чиг үүргийн албан хаагчдыг чадавхжуулах, тогтвортой ажиллуулах тогтолцоо сул байгаагаас шалтгаалан хариуцсан албан тушаалтнуудын гэрээний талаарх мэдлэг дутмаг байх, орчуулга болон тайлан, мэдээний чанар, стандарт хангалтгүй байх, гэрээний талаарх архивын мэдээлэл хангалтгүй байх зэрэг

нийтлэг дутагдал гарч байна. Үүний зэрэгцээ гэрээний хэрэгжилтийн тайлан хэлэлцүүлсэн дүн зөвлөмжийг Улсын Их Хурал, Засгийн газарт танилцуулах, биелэлтийг хангуулах шийдвэр гаргуулах механизм бүрдээгүй, салбар хоорондын шинжтэй гэрээний зөвлөмжийн биелэлтийг хэрхэн хангах талаар тодорхой зохицуулалтгүй байгаа нь олон улсын гэрээ зөвлөмжийг нэг мөр бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж орхигдоход хүргэж байна.

### 3. Төсөв санхүүжилтийн асуудал

Олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн боловсруулах шаардлагатай хэлний орчуулах, хүргүүлэх, хамгаалах зөвлөмжийг орчуулах, хэрэгжүүлэх зардлыг энэ хуулийн 25.1-д заасан байгууллага өөрийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ гэж, 36 дугаар зүйлийн 36.1-д олон улсын гэрээ байгуулах асуудлаар хэлэлцээ хийх, томилолтоор ажиллах, төлөөлөгчид хүлээн авах хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын гэрээ байгуулах, олон улсын гэрээнд нэгдэн орохтой холбоотой судалгаа хийх, хэрэгжилтийн тайлан хамгаалах, олон улсын гэрээг орчуулах, орчуулан хянан баталгаажуулах зардлыг тухайн олон улсын гэрээг хариуцан байгуулж байгаа төрийн захиргааны төв байгууллага санхүүжүүлнэ гэж, Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолд холбогдох тайланг боловсруулж, хэлэлцүүлэхэд шаардах хөрөнгийг жил бүр төсвийн багцдаа тусган санхүүжүүлж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосон хэдий ч хэрэгждэггүйд ажлын хэсгийн явцад ажиглагдлаа.

Гэрээ, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахад төсөв санхүүгийн байдлыг давхар шийдэж байж хэрэгжих нөхцөл бүрддэг бөгөөд төсөв санхүүгийн



хүндрэлтэй байдлаас шалтгаалан төлөвлөсөн ажил хэрэгждэггүй байдал байсаар байна. Тухайлбал олон улсын гэрээний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7, 36 дугаар зүйлийн 36.1-д олон улсын гэрээний орчуулгын зардлыг гэрээ хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар заасны дагуу гэрээний тайлан боловсруулах, орчуулахад шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт суулгах саналаа холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг боловч улсын нэгдсэн төсөв боловсруулахад тухайн төсвийг хасдаг асуудал гарсаар байна. Үүнээс шалтгаалан ихэнх төрийн захиргааны төв байгууллага өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан гэрээний орчуулга хийж ирсэн хэдий ч нэн хангалтгүй байна.

Олон улсын гэрээний зүйл, заалтыг нэг томъёоллоор орчуулаагүй, холбогдох нэмэлт тайлбарыг орчуулж хэвшээгүй зэргээс шалтгаалан гэрээний зүйл, заалтыг харилцан адилгүй ойлгуулах, тайлбарлах, хэрэглэх асуудал практикт гарч байна.

Төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан нэгдэн орсон гэрээний талаарх мэдээлэл ойлголтыг иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажил хангалттай хийхгүй байгаа нь иргэдэд энэ талаар мэдлэг ойлголтыг бий болгож байж чадахгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан ажлын хэсэг дараах асуудлыг тусгасан Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Хууль зүйн байнгын хороонд танилцуулж байна. Үүнд:

1. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх, тайлагнах, хэлэлцүүлэх, хяналт, шинжилгээ хийх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор олон улсын гэрээний тухай хуульд

өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан Улсын Их хуралд өргөн мэдүүлэх,

2. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний дагуу Арьс үндсээр алагчлах үзлийг устгах хороо, Эрүү шүүлтийн эсрэг хороо, Хүчээр алга болгохын эсрэг хороо нь манай улсын иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хянан хэлэлцэх эрхийг хүлээн зөвшөөрч, энэ тухайгаа холбогдох гэрээний хороодод хүргүүлэхийг Засгийн газарт даалгах,

3. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилт хариуцах төрийн захиргааны байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл дамжуулах, солилцох цахим мэдээллийн нэгдсэн санг бий болгох,

4. Монгол Улсын олон талт олон улсын гэрээ болон холбогдох тайлбаруудыг орчуулж хэвлэн нийтлэх, олон улсын гэрээний хэрэгжилт хариуцсан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, олон улсын гэрээний талаарх иргэдийн боловсролыг дээшлүүлэх, олон улсын гэрээний зүйл заалтыг практик хэрэглээг бий болгох зорилгоор хуульчдад зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулах. Гэрээний хэрэгжилтийг тайлагнахад шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгуулах арга хэмжээ авах,

5. Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судлан үзэж, холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Энэ талаар тусгайлсан хавсралт бэлдэж танилцуулж байна. Асуудлыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Ингээд тайлан юу. энэ тогтоолын төслийг сая гол

агуулгыг нь Мөнх-Оргил гишүүн танилцуулчихлаа. Тогтоолын төслийг бүгдэд нь тараасан байгаа. Тайланг ч бас тараасан байгаа.

Тэгээд ингээд тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Асуулт, тийм. Ингэе. Энэ тайлантай холбогдуулаад үг хэлэх, асуух асуултаа нэгтгэчихье. Тэгээд нэрсээ өгнө үү, гишүүд. Алга байна. Тийм энэ тайлантай холбоотой нэгтгэж болж байгаа юм.

Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

**Б.Энх-Амгалан:** Баярлалаа. “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Энэ зөв зүйтэй.

Монгол Улс олон улсын олон талт гэрээнд нэгдэн орж хариуцлага хүлээдэг. Тэр хүлээсэн хариуцлагынхаа хүрээнд бас холбогдох байгууллагууд энэ гэрээний хэрэгжилтийг хамтран хэрэгжүүлдэг. Сая танилцуулгаас 30 гаруй гэрээний тайлан боловсруулж, гаргаж байх тухай ийм асуудал яригдаж байна. Тэгээд энэ дээрээс би нэг 3 зүйлийг маш тодорхой асууя.

1 дүгээрт, энэ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын протоколд Монгол Улс нэгдэн орсон. Үүнтэй холбоотойгоор энэ эрүү шүүлт тулгах сэдэл, эсхүл шалтгаан, гутаан доромжлох, шахалт үзүүлэх шалтгаан зэрэг нь гуравдагч этгээд хамааралтай байх талаар заасан байдаг. Тэгэхээр энэ эрүүдэн шүүхтэй холбоотой, хүчээр мэдүүлэг авахтай холбоотой, хууль бусаар мэдүүлэг бүрдүүлэхтэй холбоотой энэ асуудлаар цаашидаа ер нь яах вэ? Энэ тал дээр ямархуу өөрчлөлтүүд хуулиудад оруулахаар ингэж төлөвлөж байна?

Үүний нэг тод жишээ бол Зоригийн хэргийн асуудал байгаа юм. 1 дэх нь энэ.

2 дахь нь, Монгол Улс яах вэ, ингээд бас алдаа гаргаж байсан түүх бий. Тэгээд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсээ ингээд цагаатгадаг. Тэгээд цагаатгах ажлыг хариуцсан улсын комисс гаргаад тэгээд цагаатгасан хүмүүсийнх нь ар гэрт яах вэ, хойч үе нь буюу Монголын төр татвар төлөгчдийнхөө мөнгөөр ингээд хохирлыг нь төлж байгаа.

Тэгвэл хэлмэгдүүлсэн хүмүүсийг яах вэ? Төрийн албан хаагч түүний дотор тусгай чиг үүргийн субъектийн албан хаагчид хууль тогтоох, хууль хэрэгжүүлдэг байгууллагын энэ албан хаагчдад хэрвээ энэ албан хаагчдын үйлдсэн эрүү шүүлт тулгасан, зүй бус харьцсан энэ үйлдлийг энэ тусгай субъектийн үйлдсэн хэргийг ер нь цаашидаа яаж мөрдөн шалгах юм. Цаашидаа энэ дээр ямар арга хэмжээ авах юм. Энэ нөхцөл байдал дээр ямархуу энэ олон улсын гэрээ конвенцод хүлээсэн үүргээ биелүүлж цаашид явах юм бэ гэдэг тал дээр асууя.

3 дугаарт нь, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт, түүний 2 дугаар протоколыг Монгол Улс хүлээн зөвшөөрч элсэн орсон. Энэ тал дээр улс төрийн өрсөлдөгчөө захиалгаар намнадаг ийм нөхцөл байдлууд Монгол Улсын түүхэнд байгаа. Тэгэхээр үүнийг цаашидаа яах юм. Үүнийг яаж хангах вэ гэдэг ийм 3 асуудал дээр нэг хариулт өгөөдхөөч.

**Д.Цогтбаатар:** Мөнх-Оргил гишүүн хариулах уу? Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Монгол Улс яг нэгдэж орсон олон талт 255 гэрээ конвенц байгаа юм. Түүн дотроос бид нар яагаад энэ 30-ийг сонгож авсан юм бэ гэхээр энэ 30 конвенцоор бид нар конвенцын

хэрэгжилтийг яаж хангаж байна гэдэг талаар тогтмол ОУБ-д тайлагнадаг. ОУБ-аас тухайн конвенцын хороод экспертүүдээс бүрдсэн хороод манай тайланг хэлэлцээд нөгөө шүүмжлэл, санал зөвлөмж өгдөг 30 конвенц байгаа байхгүй юу. Тэрийг нь л сонгож авч байгаа юм. Түүн шиг 255-аар бүгдээр нь бид нар нэгд нэгэнгүй ярих бололцоо байхгүй. Түүн дунд онцгой ач холбогдолтой таны саяын ярьсан 3 конвенц байгаа юм. Энэ Алагчлан үзэх үзлийг устгах хороо, Эрүү шүүлтийн эсрэг хороо, Хүчээр алга болгохын эсрэг хороо гээд.

Эрүү шүүлтээр юу хийх вэ гэдэг асуудал яригдаж байгаа юм. Энд ерөөсөө нэг чухал юм баймаар байгаа юм. Бид нар энэ тогтоолын төсөл дээрээ хамгийн 2 дугаар заалт болгоод оруулчихсан. Энэ яах вэ гэхээр Эрүү шүүлтийн эсрэг хороонд Монгол Улсын иргэд гомдол гаргах, гаргасан гомдлыг нь Эрүү шүүлтийн олон улсын хороо хэлэлцээд шийдвэр гаргадаг. Тэр шийдвэрийг нь Монгол Улсын Засгийн газар хүлээн зөвшөөрч хэрэгжүүлдэг тэр бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрч өгмөөр байгаа юм. Үүнийг хүлээн зөвшөөрөөгүй болохоор Монгол Улсын иргэдээс НҮБ энэ Эрүү шүүлтийн хороонд оруулсан хүсэлтүүд хэлэлцэх бололцоогүй болчихдог. Танайх энэ бүрэн эрхийг зөвшөөрөөгүй ээ. Тийм учраас танайх энэ гомдлыг чинь хүлээж авахгүй гээд. Дотооддоо асуудал тавихаар тэр нь та сая хэллээ шүү дээ, шүүхээр замхраад алга болчихдог. Энэ дээр нэг ийм ойлголт байгаа юм. Бид нар эрүүдэн шүүнэ гэхээр л нөгөө Зоригийн хэрэгт холбогдсон 2 иргэн шиг л бүр тэгж л ингээд л яргалаад л. Тийм ээ. Зодоон цохион болж байж л эрүүдэн шүүнэ гэж ойлгоод байгаа байхгүй юу. Тийм биш. Жишээ нь одоо, чи нэг нөхрийг мөрдөн байцаагч дуудаад чи хэргээ хүлээ. Үгүй ээ, би хэрэг хийгээгүй. Тийм үү. Чи хэргээ хүлээхгүй байна уу. Тэгвэл гараад сууж бай. Тэгээд өглөө 9 цагаас орой 9 цаг үүдэндээ суулгачихна гэдэг бол ерөөсөө эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр л

байхгүй юу. Ерөөсөө эрүүдэн шүүлтийн хамгийн тод тодорхой хэлбэр.

Эсвэл хэрэг хүлээ. Хүлээхгүй. Тэгэхээр нь хэргийн материалыг олон нийтэд хэвлэлээр, олон нийтийн сүлжээгээр задлаад тавьчихна гэдэг нь өөрөө эрүү шүүлтийн нэг хэлбэр. Энэ ерөөсөө эрүүдэн шүүлт байгаа байхгүй юу. Тэр хүнийг гэм буруу нь тогтоогүй байхад олон нийтийн сошиалын шүүхээр оруулаад өөрийг нь, ар гэрийг нь, ах дүү нарыг нь, найз нөхдийг нь буруутан болгох нийгмийн уур амьсгал бүрдүүлж байна гэдэг чинь өөрөө эрүү шүүлтийн нэг хэлбэр. Энэ болгоныг хүлээн зөвшөөрч энэ асуудлуудыг шийдэхийн тулд дотоодын хууль тогтоомж гэхээсээ илүүтэй миний бодлоор энэ Эрүү шүүлтийн эсрэг хорооны бүрэн эрхийг бид нар хүлээн зөвшөөрөөд тэнд Монгол Улсын иргэд намайг ингэж эрүүдэн шүүчихлээ, шүүхийн байгууллагаар ийм ийм ийм асуудал оруулаад шийдэгдсэнгүй. Үүнийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд шийдэж өгөөч ээ гэдэг хүсэлт гаргахыг нь хүлээн зөвшөөрөх нь чухал гэж гэж бодож байгаа юм. Тэгээд үүнийг оруулж байгаа юм.

Тэгээд энд ингэж оруулах манай Үндсэн хуулийн заалтууд ч байж байгаа юм. Манай Үндсэн хуулийн 10-д ингээд заачихсан байхгүй юу. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж. Ерөөсөө манайх энэ эрүүдэн шүүлтийн эсрэг конвенцод нэгдээд орчихсон байгаа нь дотоодын хууль тогтоомждоо ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй байсан ч гэсэн шууд энэ конвенцыг ... /минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Мөнх-Оргил гишүүний микрофоныг гүйцээгээд өгье. Яг чухал юм дээр зогсож байна.

**Ц.Мөнх-Оргил:** Хэлмэгдүүлэлт дээр олон улсын гэрээний заалтууд байхгүй. Гэхдээ энэ дээр Монгол Улсын хууль тогтоомж үйлчилж байгаа. Зөвхөн цагаатгалын тухай хууль биш. Ер нь төр бол иргэдээ хэлмэгдүүлсэн төрийн албан хаагчдын буруутай үйлдлийг төр хариуцаж байгаа шүү дээ. Тэгээд буруутай төрийн албан хаагчдаасаа буцаагаад төр нь хохирлоо нөхөн төлүүлэх эрх зүйн заалт нь хэвээрээ байж байгаа юм. Энэ заалт хэвээрээ л үйлчлэх болов уу л гэж бодож байна.

Фактын 2 дугаар протокол дээр манайх нэгдэж орсон. Энэ бол манай дотоодын хууль тогтоомжид яг цав тусгагдсан, бүхэлдээ хэрэгжиж байгаа ийм л заалт гэж ойлгож байгаа. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Тэгвэл юу, надад нэг товчхон асуулт байна. Мөнх-Оргил гишүүн ээ, энд та сая хэллээ. Нөгөө манайх соёрхон баталсан бол тэр шууд манай Монголын дотоодын хууль тогтоомж болоод явж байгаа. Тэр утгаараа манай хууль чинь бүр ингээд тодорхой заачихсан байгаа шүү дээ. Хэрэв дотоодын мөрдөгдөж байгаа хуультайгаа зөрчилдвөл шууд тэр нэгдэн орсон гадаадын олон улсын гэрээ хэлэлцээрээ бариад явна. Өөрөөр хэлбэл шууд давамгайлах үйлчлэлтэй болоод явж байгаа. Тэгэхээр 1 ийм юм асуумаар байна.

Өнөөдөр шүүхийн практик дээр олон улсын тэр гэрээ, хэлэлцээрийг манай хууль болгож оруулж ирээгүй шууд соёрхон баталчихсан байгаагаар нь шүүх дээр шууд аваад хэрэглэж байгаа тохиолдлууд хэр түгээмэл байна вэ? Энэ дээр ямар нэгэн статистик үзүүлэлт байна уу? Эс үгүй бол ямар нэгэн шалтгаанаар цааргалаад үүнийг хэрэглэхгүй байгаа тохиолдол бас энэ хяналтын үеэр гарав уу?

Ажлын хэсгээс хариулах уу. Хууль зүйн яам. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ нөгөө их чухал асуудал байгаа юм. Тэгээд энэ Монгол Улсын шүүхүүд сүүлийн 5-6 жилийн хугацаанд Монгол Улсын нэгдэж орсон соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцын заалтуудыг шууд дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил тэр олон улсын гэрээ конвенцын заалтыг эш татаад хэрэг шийддэг, асуудал шийддэг, маргаан шийддэг практик тогтоож байгаа юм. Тэгэхдээ их удаан.

Бид нар энэ ажлын хэсгийн явцад Дээд шүүх, Судалгааны хүрээлэн эд нартай ярьж байхад сүүлийн 5 жилийн дотор ийм практик ийм маргаан шийдсэн 3 асуудал гарсан. Алагчлан үзэхийн эсрэг конвенц, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц гээд. Ингээд 3 удаа энэ шүүхэд шууд хэрэглэсэн байгаа юм. Энэ дээр манай шүүх нөгөө Үндсэн хуулийн заалтаараа соёрхон баталсан. Тэгээд албан ёсоор хэвлэгдсэн хууль хэрэглэгдэх ёстой гээд. Тэгээд албан ёсоор хэвлэх олон улсын гэрээ конвенцоо бид нар албан ёсоор хэвлэх асуудал дээрээ их удаашралтай байгаад байгаа байхгүй юу. Том том конвенцуудад нэгдээд орчихдог. Тэрийгээ орчуулаад төрийн мэдээлэл дээр тавигдаж байх ёстой. Төрийн мэдээлэл дээр тавигдахаар нөгөөдөх нь шүүгч нарын гар дээр очиж байх ёстой. Тэр ажил жоохон удаашираад ер нь бол нөхөөд л яваад байгаа юм, нөхөөд л яваад байгаа юм. ГХЯ энэ ажлыг зохион байгуулж байгаа юм. Гэхдээ орчуулгын асуудал. Манай шүүгч нар бол Монгол хэл дээр л орчуулагдаж албан ёсоор хэвлэгдсэн конвенцыг хэрэглэх ёстой. Тэгээд тэрийг зөв орчуулж, тэрийг зөв хэвлэнэ гэдэг нь өөрөө нэг талаас техник, нөгөө талаас шүүгч, шүүхийн байгууллагууд, шүүгч нарын дунд тийм нэлээн чухал чухал конвенц болгоноор нь миний бодлоор сургалтууд явуулмаар юм байна лээ. Яг энэ заалтыг шууд ингэж



хэрэглэнэ шүү. Энэ заалт манай хуулийн энэтэй ингээд нийцэж байгаа юм шүү. Үүнийг ингэх ёстой юм шүү гэдэг энэ сургалтууд явуулах ёстой юм байна лээ. Өөрөөр хэлбэл нөгөө эрх зүйн соёл бий болгох, шүүхийн үйл ажиллагаанд шинэ практик нэвтрүүлэх, шүүгч нар энэ тал дээр их тийм нааштай хандаж хэрвээ ингээд албан ёсоор хэвлээд, Монгол хэл дээр ойлгомжтой албан ёсоор хэвлээд энэ дээр тодорхой сургалтууд явуулчих юм бол бид нар энэ заалтуудыг хэрэглээд явахад асуудал шийдэхэд их амар байна. Үүнийг цааш нь улам нэвтрүүлж өгөөч ээ гэдэг сонирхол байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Ойлголоо. Энэтэй тэгэхээр холбогдуулаад энэ юу Хууль зүйн яаманд бас хандаад нэг юм хэлчихмээр байна.

Мөнх-Оргил сайд сая чухал деталь ярьж байна шүү дээ. Манай шүүх нөгөө дотоодын хууль тогтоомжийг хэрэглэх процедураа энд шууд ашиглаад байна шүү дээ. Заавал хэвлэгдсэн байх ёстой гэдэг шаардлага. Олон улсын хуулиараа нөгөө нэгдэн орж байгаа гэрээнд чинь *ratification* буюу соёрхон батлах гэдэг л заалт байгаа. *ratification* буюу соёрхон батлах гэдэг олон улсын хуулийн ойлголтод эндээ хэвлэн нийтлэх гэдэг ойлголт байхгүй шүү. Энэ чинь юу гэсэн үг вэ гэхээр Их Хурал дээр соёрхон батлаад л Монгол Улс тэр конвенцынхоо дагуу олон улсын хуулийн өмнө шууд хариуцлагаа хүлээгээд эхэлж байгаа юм. Тэрийгээ биелүүлээгүй бол Монгол Улс үүнийг нь хэвлэн нийтлээгүй байгаа юм байна. Тэгэхээр Монгол Улсад энэ дээр нь хариуцлага тооцохгүй гэдэг асуудал байхгүй шүү дээ.

Тийм учраас хэвлэн нийтлэгдээгүй байхдаа ч албан ёсны орчуулга нь байхгүй байсан ч Их Хурал дээр соёрхон батлагдлаа. Тэр гадаад хэл дээрээ Монголын хууль болоод явчхаж байгаа гэдгийг Хууль зүйн яам үүнийг анхаарах ёстой.

Тэгэхээр үүнийг тэр хэрэглээнд нь маш хурдан шилжүүлэх ажлыг зохион байгуулах ёстой. Ард иргэдийн эрх ашиг зөрчигдөхөөр ийм асуудал гарч ирээд тэгсэн хэвлэгдээгүй орчуулагдаагүй байхад шүүх аваад өмгөөлөгчид нь шууд оруулж ирээд үүнийг хэрэглэх эрхтэй бөгөөд шүүх аваад хэрэглэх үүрэгтэй болно шүү дээ. Түүнээс дотоодын процедураараа бамбай хийгээд эндээс мултрах боломж байхгүй гэдгийг тал талдаа ойлгох хэрэгтэй гэдгийг хэлмээр байна.

Ингээд юу, энэ асуудлаар үг хэлж дууслаа, гишүүд. Ингээд тайланг Монгол Улсын олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлттэй танилцлаа.

15.10 цаг

Ингээд 2 дугаар асуудалдаа оръё. Энэ яг энэ тайлантай холбогдсон тогтоол байгаа. Түрүүн Мөнх-Оргил сайд танилцуулчхаж байна лээ. Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох ОУБ-д хүргүүлэх, тайлантай холбогдуулан ОУБ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайлан, санал, дүгнэлттэй танилцсантай холбогдуулан боловсруулсан

**“Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төслийг бүгдэд нь тараасан байгаа.

Ингээд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Түрүүн танилцуулчихсан хүмүүс хэвэндээ байгаа биз дээ. Тэгвэл түрүүний хүмүүсийг бүгдийг нь танилцуулчихсан байгаа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Ингээд “Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

70 хувиар санал дэмжигдлээ. Оролцсон гишүүдийн.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Тогтоолын төслийн талаар зарчмын зөрөөтэй саналын томъёолол гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэснээр санал хураалт явуулья.

80 хувиар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын нэгдэн орсон Олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан танилцуулна.

Байнгын хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүд ирж оролцсонд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ